

АУДИТЫН КОД: САГ-2017/24/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа

Утас: 261628 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Хосжаргал

Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn

Улаанбаатар хот

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл.....	4
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	5
2.5	Дотоод хяналт.....	6
2.6	Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар.....	6
2.7	Шилэн дансны мэдээлэл.....	7
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	8
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	8
2.9.1	Зардлыг тооцооны дансаар дамжуулах бичилтийг залруулах талаар.....	8
2.9.2	Барьцааны өр төлбөрийн үлдэгдлийг залруулах талаар.....	8
2.9.3	Санхүүгийн анхан шатны баримтыг архивын нэгж болгох талаар	9
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	9
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	9
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:	9
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал.....	11
3.1	Санхүүгийн анхан шатны баримт.....	12
4	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	13
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	13
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	13
4.3	Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	14
4.4	Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16
4.6	Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	18

Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн
2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

1 Аудитын гэрчилгээ



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.04.25 № 755

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
ДАРГА Х.ЭНХЖАРГАЛ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Авлигатай тэмцэх газрын дарга Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам"-ын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн нэгтгэсэн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

\\10.10.10.20\Bichig_Kherel\Yawsan_Bichig\2017\0425\CAAG.docx


075136

Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн
2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Зөрчилгүй санал дүгнэлт

Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Авлигатай тэмцэх газрын дарга Х.Энхбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 4 дүгээр сарын 10-наас 2017 оны 4 дүгээр сарын 20-ны хооронд хийж, аудитын тайланг 2017 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ц.Хосжаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Авлигатай тэмцэх газрын дарга 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Авлигатай тэмцэх газрын даргын 2017 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 01/2736 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Авлигатай тэмцэх газар нь авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, энэ хуульд заасан этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан, төрийн тусгай байгууллага юм.

Авлигатай тэмцэх газар нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1. Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах;
2. Хуульд заасан албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хянан шалгах ажлыг зохион байгуулах;
3. Авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэл, мөрдөн байцаалт явуулах ажлыг гүйцэтгэх.

Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна Авлигатай тэмцэх газрын удирдлагаас тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 2.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 5 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 7 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2014 онд боловсруулж баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн зарим зүйл заалт Сангийн яамнаас 2016 онд авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, журам заавартай нийцэхгүй байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт дараахь асуудлыг дэлгэрэнгүй тусгах нь зүйтэй. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх тухай Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журам, маягт аргачлалтай холбоотой асуудал;
- Төсвийн орлого, зарлагын эдийн засгийн ангилалтай холбоотой асуудал;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас шинээр гарсан бодлого шийдвэртэй холбоотой асуудал;

Авлигатай тэмцэх газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн нэгтгэсэн тайлан нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамж ашиглажээ.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Авлигатай тэмцэх газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад бүртгэлээр тавих дотоод хяналт хэвийн гэж үзлээ.

Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод аудитын албаны үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргалаа.

Авлигатай тэмцэх газрын дарга 1 дотоод аудитор ажиллуулахаар шийдвэрлэжээ.

Дотоод аудитор төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалт, санхүүгийн тайлан, аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлж, эрсдэлийн удирдлагаар хангах ажлыг эрхлэн гүйцэтгэж байна.

2.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Авлигатай тэмцэх газрын даргын төсөвт 9 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж урсгал зардалд дээрх хуулиар 8,785.6 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх зарим мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 8,770.7 сая төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь Сангийн яам улс орны эдийн засгийн хүндрэлтэй байдлын улмаас төлөвлөсөн зарим зардлын эрхийг хязгаарлах бодлоготой холбоотой 8.3 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн, мөн зарим зардал дутуу зарцуулагдсанаас 5.5 сая төгрөгийг төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлангаас үзэхэд төсвийн гүйцэтгэлд анхаарал татахуйц их хэмжээний хэлбэлзэл алга байна.

Авлигатай тэмцэх газар тайлант хугацаанд Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар баталсан дараах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.

- Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэгийн бүрдүүлэлтийг хянах
- Авлигын эсрэг мэдээлэл, сурталчилгаа хийх
- Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тухай сургалтад хамрагдах
- Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаархи төсөөллийн судалгаа хийх
- Хүүхдийн шударга байдлын судалгаа хийх
- Төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээ хийх
- Шударга ёс эмхэтгэл гаргах
- Авлигын индексийн судалгаа хийх
- Байгууллага, иргэдийн гомдол, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэх

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн зорилтот түвшин хөтөлбөр тус бүрээр бүрэн хангагдсан байна. Тухайлбал:

- Үнэлгээнд Улсын Их Хурлаас байгуулагддаг 7 байгууллага, 13 яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч 23 агентлаг, аймаг, нийслэл 22, нийслэлийн 9 дүүрэг, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 53 хуулийн этгээд, нийт 127 байгууллага хамрагдаж, улсын дундаж үнэлгээ 61,7%-тай үнэлэгдсэн байна.
- Олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр 236 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 14300 хүнийг сургалтад хамруулжээ.
- 2016 онд нийт 14 төрлийн 8015 ширхэг гарын авлага, тараах материалыг төрийн 48 байгууллагад, үүнээс 3299 ширхэгийг 21 аймагт, 845 ширхэгийг төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэд, оюутан залууст, 3871 төрийн төв, нийслэлийн засаг захиргааны байгууллагад тус тус түгээжээ.
- Шударга байдлын үнэлгээний 2015 оны судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах ажлыг нэгдсэн удирдамжаар ханган ажиллав. Тус судалгаанд 62 байгууллагаас төрийн үйлчилгээ авсан 2370 иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл, 1410 төрийн албан хаагч, 630 шинжээчээс цуглуулсан мэдээллийг гүйцэтгэгч компаниас хүлээн авч, судалгааны тооцооллыг хийж үр дүнг гаргаж, тайланг боловсруулж, хэвлүүлэв.
- 2016 онд улсын хэмжээнд ХАСХОМ гаргах нийт 39853 мэдүүлэг гаргагч бүртгэгдсэнээс 39850 мэдүүлэг гаргагч буюу 99.9 хувь нь мэдүүлгээ бүртгүүлсэн байна. Үүнээс хуульд заасан хугацаанд 39848 мэдүүлэг гаргагч бүртгүүлснээс 2 мэдүүлэг гаргагч хугацаа хожимдуулсан, 3 мэдүүлэг гаргагч мэдүүлгээ гаргаж өгөөгүй бөгөөд зөрчил гаргасан албан тушаалтнуудад Авлигын эсрэг хуулийн дагуу сануулах болон ажлаас халах хүртэлх хариуцлагыг тооцуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Авлигатай тэмцэх газрын дарга төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

Авлигатай тэмцэх газар өөрийн цахим хуудсанд ил тод байдал цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна.

1. Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр)
2. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)

3. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)
4. Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)
5. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил, үйлчилгээний гүйлгээ (Тухай бүр)
6. Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр)

Дээрх мэдээллийг нийтэд ил тод мэдээлсэн талаарх нотлох баримтыг ажлын баримт материалд хадгалав.

Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2016 оны байдлаар нийцлийн аудит хийхэд Авлигатай тэмцэх газартай холбоотой зөрчил дутагдал илрээгүй байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу тохиолдох магадлалтай дансанд хамаарах уламжлалт 6 дансанд 12, 4 дансанд хамаарах 5 хяналтын эрсдэлийг агуулж байж болзошгүй гэж урьдчилан тооцоолсон бөгөөд батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 7 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэлээ.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны "Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах" гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах алдаа, зөрчил илэрснийг доорх байдлаар шийдвэрлэсэн болно.

2.9.1 Зардлыг тооцооны дансаар дамжуулах бичилтийг залруулах талаар

Сангийн сайдын 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар" -ын 3.2 "Үйл ажиллагааны зардлыг тайлант хугацааны туршид аккруэл суурьт үндэслэн холбогдох зардлын дансдуудад хуримтлуулан бүртгэнэ. Аккруэл суурь бүртгэлийн хувьд ажил гүйлгээ гарсан бөгөөд мөнгөн дүн нь хэмжих тодорхойлох боломжтой болсон үед төлбөр хийгдсэн эсэхээс үл хамааран гарсан зардлаас тайлант хугацаанд хамаарах хэсгийг хүлээн зөвшөөрч бүртгэнэ" гэсэн заалтыг зөрчиж 144.6 сая төгрөгийн тогтмол зардал болон ажил үйлчилгээний төлбөрийг нэхэмжлэхийн дагуу өглөг дансанд хуримтлуулан бүртгэхгүйгээр төлбөрийг шилжүүлэх бүрт зардалд шууд бүртгэсэн.

Шийдвэрлэсэн нь: Нэхэмжлэхийн дүнгээр өглөг дансанд бүртгэж, өглөг данснаас төлбөр гүйцэтгэсэн мөнгөн хөрөнгийн дүнгээр хааж залруулах бичилт хийлгэв.

2.9.2 Барьцааны өр төлбөрийн үлдэгдлийг залруулах талаар

Сангийн сайдын 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар" -ын 4.51. "Өр төлбөр гэдэг нь төлбөрийг барагдуулахад эдийн засгийн өгөөж буюу үйлчилгээний чадавхид биелэлээ олсон байгууллагын нөөц гадагш урсахаар хүлээгдэж байгаа, өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн өнөөгийн хариуцлага юм" гэсэн заалтыг хангаж буй 1,541.4 сая төгрөгийн өр төлбөрийг тайлант оны үр дүнгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрч буруу тайлагнасан, өмнөх оны 685.1 сая төгрөгийн өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй.

Шийдвэрлэсэн нь: Үр дүнгийн тайланд орлогыг 1,541.4 сая төгрөгөөр, өмнөх үеийн үр дүнг 685.1 сая төгрөгөөр тус тус бууруулж, өр төлбөр дансны дүнг 2,226.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэх залруулга хийлгэв.

2.9.3 Санхүүгийн анхан шатны баримтыг архивын нэгж болгох талаар

Тайлант оны харилцахын зарлагын баримтыг дэлгэрэнгүй бүртгэлийн дагуу холбогдох гүйлгээ бүрээр хавсарган дугаарлаж эмхлэн цэгцлээгүй, харилцах, кассын баримт холилдож үдэгдсэн зэрэг нь Сангийн сайдын 276 дугаар тушаалаар баталсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 7.2-т “...бэлэн мөнгөний гүйлгээ тус бүрийг кассын дэвтэрт бүртгэж, кассын тайлан гаргаж кассын дэвтрийн хуудас бүрийг дугаарлан нягтлан бодогчид шилжүүлэн өгч хянуулж байна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төслийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 388 дугаар тушаалаар батлагдсан төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх зааврын дагуу иж бүрэн бэлтгэх, Сангийн сайдын 276 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөв.

2.10 АНХААРАЛ ТАТАХҮЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал хандуулах бусад асуудал түүвэрлэн үзсэн горимын хувьд байхгүй байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

2017 оны санхүүгийн тайланд хийх аудитаар үндсэн хөрөнгө болон бараа материалд бодитой оршин байгаа эсэхэд горим хэрэгжүүлэх зүйтэй гэж үзлээ.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 2,371.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнийг аудитын явцад залруулга хийлгэв. Эдгээр зөрчлийг асуудлын бүртгэлд нэгтгэж, баталгаажуулсан болно.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2015 оны 240 дүгээр тушаалаар баталсан “Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитад итгэл үзүүлэхэд баримтлах журам”-ын шаардлагыг хангаж байсан тул Төрийн аудитын тухай хуулийн 18.4-т заасны дагуу тус байгууллагын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд итгэл үзүүлсэн.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 9,420.3 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 188.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 2.12-д тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын Олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Авлигатай тэмцэх газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

3.1 САНХҮҮГИЙН АНХАН ШАТНЫ БАРИМТ

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Тайлант оны харилцахын зарлагын баримтыг дэлгэрэнгүй бүртгэлийн дагуу холбогдох гүйлгээ бүрээр хавсарган дугаарлаж эмхлэн цэгцлээгүй, харилцах, кассын баримт холилдож үдэгдсэн зэрэг нь Сангийн сайдын 276 дугаар тушаалаар баталсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 7.2-т “...бэлэн мөнгөний гүйлгээ тус бүрийг кассын дэвтэрт бүртгэж, кассын тайлан гаргаж кассын дэвтрийн хуудас бүрийг дугаарлан нягтлан бодогчид шилжүүлэн өгч хянуулж байна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төслийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 388 дугаар тушаалаар батлагдсан төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх зааврын дагуу иж бүрэн бэлтгэх, Сангийн сайдын 276 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Анхан шатны баримт алга болох, бүрдэл хангагдахгүй байх

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

Үнэн зөв байдал - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх

4 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Тайлангийн үзүүлэлт	/мян.төг/	
	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,779,946.5	5,210,147.3
МӨНГӨН ХӨРӨНГӨ	693,244.3	2,233,636.7
АВЛАГА	1,940.0	-
УРЬДЧИЛГАА	11,897.9	117,488.6
БАРАА МАТЕРИАЛ	3,072,864.2	2,859,022.0
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,247,708.9	6,998,549.0
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,247,708.9	6,998,549.0
Биет хөрөнгө	7,147,980.7	6,942,669.0
Биет бус хөрөнгө	99,728.2	55,880.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	11,027,655.3	12,208,696.3
НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	2,226,592.2
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	2,226,592.2
Урьдчилж орсон орлого	-	2,226,592.2
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	11,027,655.3	9,982,104.1
Засгийн газрын хувь оролцоо	11,027,655.3	9,982,104.1
Засгийн газрын оруулсан капитал		
/Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,489,727.6	1,489,727.6
Хуримтлагдсан үр дүн	9,537,927.7	8,492,376.5
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	11,027,655.3	12,208,696.3

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Тайлангийн үзүүлэлт	/мян.төг/	
	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,931,166.4	9,112,642.5
ТАТВАРЫН ОРЛОГО	59,778.4	-
Орлогын албан татвар	59,778.4	-
Хувь хүний орлогын албан татвар	59,778.4	-
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	65,496.6	407,446.0
Нийтлэг татварын бус орлого	65,496.6	248,042.8
Тусламжийн орлого	-	159,403.2
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,805,891.5	8,705,196.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	10,405,284.5	9,500,158.8
УРСГАЛ ЗАРДАЛ	10,405,284.5	9,500,158.8

Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн
2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,245,807.6	9,311,967.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,607,613.4	3,683,458.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	254,471.8	251,869.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,904.1	81,000.0
Хангамж, бараа материалын зардал	249,170.6	180,576.1
Нормативт зардал	-	4,347.0
Эд хогшил, урсгал засварын зардал	44,084.1	36,484.3
Томилолт, зочны зардал	149,823.4	81,541.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,294,213.8	3,606,124.1
Бараа үйлчилгээний бусад зардал	1,583,526.5	1,386,566.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,159,476.9	188,191.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-474,118.1	-387,516.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	19,486.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	287,706.6	2,759.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-761,824.7	-370,789.8

4.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	/мян.төг/
			Нийт цэвэр хөрөнгө /өмч
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,817,051.3	0.0	11,817,051.3
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-27,571.3	0.0	-27,571.3
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,789,480.0	0.0	11,789,480.0
Тайлант үеийн үр дүн	-761,824.7	0.0	-761,824.7
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,027,655.3	0.0	11,027,655.3
2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	11,027,655.3	0.0	11,027,655.3
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-674,761.4	0.0	-674,761.4
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,352,893.9	0.0	10,352,893.9
Тайлант үеийн үр дүн	-370,789.8	0.0	-370,789.8
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,982,104.1	0.0	9,982,104.1

4.4 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	/мян.төг/	
	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	9,874,440.9	10,406,436.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	68,549.4	1,701,239.6
Нийтлэг татварын бус орлого	68,549.4	1,541,836.4
Тусламжийн орлого	-	159,403.2
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,805,891.5	8,705,196.5
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,847,826.7	7,935,961.9
УРСГАЛ ЗАРДАЛ	9,847,826.7	7,935,961.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,988,349.8	7,747,770.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,607,107.2	3,682,915.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	254,471.8	251,869.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,904.1	81,000.0
Хангамж, бараа материалын зардал	167,203.3	198,182.5
Нормативт зардал	39,999.0	5,000.0
Эд хогшил, урсгал засварын зардал	49,430.9	47,950.2
Томилолт, зочны зардал	127,939.3	82,178.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,484,516.1	3,216,194.5
Бараа үйлчилгээний бусад зардал	194,778.2	182,480.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	859,476.9	188,191.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	26,614.1	2,470,474.2
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	48,627.1	946,799.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	48,627.1	946,799.4
Дотоод эх үүсвэрээр	48,627.1	946,799.4
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-48,627.1	-946,799.4
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН Г ҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	16,717.6
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	2,759.9
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-22,013.0	1,540,392.4

Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн
2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	715,257.3	693,244.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	693,244.3	2,233,636.7

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	/мян.төг/	
			Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,785,638.8	8,770,723.0	14,915.8	99.8
УРСГАЛ ЗАРДАЛ	8,785,638.8	8,770,723.0	14,915.8	99.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,602,897.9	8,587,998.7	14,899.2	99.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,683,652.7	3,682,915.6	737.1	100.0
Үндсэн цалин	3,550,359.1	3,569,469.1	-19,110.0	100.5
Унаа хоолны хөнгөлөлт	133,293.6	113,446.5	19,847.1	85.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	254,845.9	251,869.0	2,976.9	98.8
Тэтгэврийн даатгал	139,107.5	140,268.6	-1,161.1	100.8
Тэтгэмжийн даатгал	14,967.9	16,355.3	-1,387.4	109.3
ҮОМШӨ-ний даатгал	18,709.8	20,284.8	-1,575.0	108.4
Ажилгүйдлийн даатгал	3,741.9	3,809.9	-68.0	101.8
Эрүүл мэндийн даатгал	78,318.8	71,150.5	7,168.3	90.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	81,000.0	81,000.0	0.0	100.0
Гэрэл, цахилгаан	44,000.0	46,433.7	-2,433.7	105.5
Түлш, халаалт	30,000.0	30,000.0	0.0	100.0
Цэвэр, бохир ус	7,000.0	4,566.3	2,433.7	65.2
Хангамж, бараа материалын зардал	200,762.0	200,762.0	0.0	100.0
Бичиг хэрэг	29,220.0	29,614.2	-394.2	101.3
Тээвэр, шатахуун	59,559.2	59,193.0	366.2	99.4
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	57,392.0	59,681.4	-2,289.4	104.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,275.1	1,552.0	-276.9	121.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	53,315.7	50,721.4	2,594.3	95.1
Нормативт зардал	5,000.0	5,000.0	0.0	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,000.0	5,000.0	0.0	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	86,626.8	86,626.8	0.0	100.0
Багаж, техник, хэрэгсэл	40,953.5	48,312.2	-7,358.7	118.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,322.7	187.0	2,135.7	8.1

Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн
2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Урсгал засвар	43,350.6	38,127.6	5,223.0	88.0
Томилолт, зочны зардал	82,178.1	82,178.1	0.0	100.0
Дотоод албан томилолт	82,178.1	82,178.1	0.0	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,043,880.7	4,033,867.1	10,013.6	99.8
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,004,366.7	3,995,086.8	9,279.9	99.8
Даатгалын үйлчилгээ	20,337.0	20,337.0	0.0	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	2,500.0	2,388.7	111.3	95.5
Тээврийн хэрэгслийн оношлогоо	337.0	337.0	0.0	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,000.0	12,000.0	0.0	100.0
Газрын төлбөр	4,340.0	3,717.7	622.3	85.7
Бараа үйлчилгээний бусад зардал	164,951.7	163,780.1	1,171.6	99.3
Бараа үйлчилгээний бусад зардал	98,453.4	97,281.8	1,171.6	98.8
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	66,498.3	66,498.3	0.0	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	182,740.9	182,724.3	16.6	100.0
Засгийн газрын урсгал шилжүүлэг	40,000.0	39,983.4	16.6	100.0
Засгийн газрын гадаад шилжүүлэг	40,000.0	39,983.4	16.6	100.0
Бусад урсгал шилжүүлэг	142,740.9	142,740.9	0.0	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	127,740.9	127,740.9	0.0	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,000.0	15,000.0	0.0	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,785,638.8	8,771,997.6	13,641.2	99.8
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	8,688,865.4	8,675,121.2	13,744.2	99.8
Улсын төсвөөс санхүүжих	8,688,865.4	8,675,121.2	13,744.2	99.8
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	130.1	-130.1	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	130.1	-130.1	
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	96,773.4	96,746.2	27.2	100.0
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	96,773.4	96,746.2	27.2	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,151.4	-2,151.4	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	3,425.9	-3,425.9	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	345	335	10	97.1
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
Төсвийн байгууллага	1	1	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	172	167	5	97.1
Удирдах ажилтан	11	15	-4	136.4
Гүйцэтгэх ажилтан	148	142	6	95.9
Үйлчлэх ажилтан	13	10	3	76.9

Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн
2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	172	167	5	97.1
Төрийн тусгай албан хаагч (ТТ)	159	157	2	98.7
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	13	10	3	76.9

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

		/ мян.төг/
Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	24,868.0	
УРСГАЛ ЗАРДАЛ	24,868.0	
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24,868.0	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,998.0	
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,998.0	
Бараа үйлчилгээний бусад зардал	16,870.0	
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,870.0	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	24,868.0	
Нэмэлт санхүүжилтийн орлого	24,868.0	
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,868.0	